МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 7 сарын 22 өдөр Дугаар А/424 Алтай хот

Хантайшир бөхийн дэвжээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир бөхийн дэвжээний хүсэлтийн дагуу түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 2000000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Алтайбаатар)-т даалгасугай.

ОРЛОГЧ Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001022